Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# АРВАЙХЭЭР СУМЫН ЗДТГ-ЫН ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН ЛУВСАНПҮРЭВИЙН ДОРЖХАНДЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нэг. “Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуйг дэмжин хөнгөлөлттэй зээл олгох” зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1.1 | Хоршоо хөгжүүлэх сангийн хороо болон хяналтын зөвлөлийн гишүүдтэй хамтран ажиллах | Журамд заасны дагуу зохион байгуулах | 100 хувь | 100 хувь | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 03/05 дугаар хурлаар хоршоог хөгжүүлэх сангийн хороо болон хяналтын зөвлөл нь тус бүр 5 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулагдсан. Журамд заасны дагуу төсөл сонгон шалгаруулах хорооны хурлын товыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 03 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлэн батлуулж журмын хүрээнд төсөл сонгон шалгаруулах хорооны хурал 1 удаа хуралдаж 4 төсөл ирснийг хэлэлцэж журмын шаардлагад нийцээгүй төсөл ирүүлсэн учир дэмжигдээгүй. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргаар батлуулсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг 2025 оны 09 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулж явцын хугацаа хэтрэлттэй 14 зээлдэгчийн гэрийн хаягаар нь очиж зээл төлүүлэх шаардлага тавьж ажилласан. Хяналт шалгалтын үр дүнд 8 зээлдэгчийн 11.2 сая төгрөгийн зээл төлөгдсөн. | 2025.03.01 2025.12.01 | 100 |
| 1.2 | Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг холбогдох хууль | 3 дугаар улиралд | 2024 онд 4 төсөлд | Шаардлага хангасан | Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг мэдээллийн самбар болон Arvaikheer.uv.mn сайтад | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, иргэдэд мэдээлэл өгч ажиллах | ТСШЗөвлөлийн хурлыг товлож төсөл хүлээн авах | 310.0 сая төгрөг | төсөл ирүүлсэн тохиолдолд олгосон байна | байршуулан иргэдэд сурталчлан ажиллаж байна. Хоршоог хөгжүүлэх сангийн журам нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/521 дүгээр тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт орсоныг төсөлд хамрагдахаар ирсэн иргэд, хоршоо, аж ахуйн нэгжид сурталчлан ажиллаж байна. Мөн Багийн Зохион байгуулагч (Эрх зүйн хөтөч), мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршооны гишүүдэд 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хоршооны тухай хуулийг сурталчлах, хоршоо хөгжүүлэх сан, шинэ хоршоо хөдөлгөөн, төрөөс баримталж буй бодлого шийдвэрийг танилцуулах, хоршоо эрхлэгчдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой удирдамж, хөтөлбөр боловсруулан сургалтыг аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар, төрийн банк, аймгийн хоршоологчдын холбоотой хамтран зохион байгуулж нийт 26 иргэн оролцлоо. Сургалтаар хоршооны үйл ажиллагаа, хөнгөлттэй зээл олголт, эргэн төлөлт, сонгон шалгаруулалт, хуулийн мэдээлэл өгч хоршооны гишүүдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн. | 2025.02.01<br>2025.12.01 | |
| 1.3 | Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдээс ирүүлсэн төслийг бүртгэж хүлээн авах | Хүлээж авсан төслийн тоо | 50 хувь | 100 хувь | Хоршоо хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн иргэдэд журмын 2.10-т заасны дагуу тайлбар мэдээллийг өгч ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр улиралд төсөл авах зарыг 02 дугаар сарын 12-ны өдрөөс 03-р сарын 12-ны өдрийн 18 цаг хүртэл авахаар зар мэдээллийг олон нийтэд зарлаж төслийг цаасан хэлбэрээр хүлээж авсан. Төсөл хүлээж авах хугацаанд 4 хоршоо төслөө ирүүлсэн. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тов зарлах асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 03 дугаар сарын 27-ны | 2025.02.01<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдөр хуралдахаар тов гарсаны дагуу тухайн өдөр хуралдаж ирүүлсэн хоршооны төслүүдийг хэлэлцэхэд журмын шаардлагад нийцээгүй учир төсөл дэмжигдээгүй. Мөн 2, 3 дугаар улиралд төсөл авахаар зар мэдээлэл оруулсан ч журмын шаардлагад нийцсэн төсөл ирүүлээгүй байна. Журмын шаардлагад нийцээгүй буюу малчдын хоршоод нь санхүүгийн тайлангүй, нийгмийн даатгал төлдөггүй, орлого, зарлага нь хоршооны дансаараа гүйлгээ хийгдээгүй зэрэг асуудлаар дэмжигдээгүй. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах хүсэлтэй 5 малчдын хоршоонд журмыг танилцуулан мэдээлэл өгч ажилласан. Сар бүрийн зээлийн эргэн төлөлтийг төлсөн зээлдэгч бүр дээр хааж, сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын дүн мэдээг Санхүүгийн албаны дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогчтой тулган ажиллаж хэвшээд байна. | | |
| 1.4 | Дэмжигдсэн төслүүдэд зээл олгоно | Нийт 210.0 сая төгрөг | 50 сая төгрөг | 160.0 сая төгрөг | Жилийн эцсийн байдлаар хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу 4 хоршоо төсөлд хамрагдахаар материал ирүүлж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тов зарлах асуудлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж 03 дугаар сарын 27-ны өдөр хуралдахаар тов гарсаны дагуу тухайн өдөр хуралдаж ирүүлсэн хоршооны төслүүдийг хэлэлцэхэд журмын шаардлагад нийцээгүй учир зээл олгоогүй байна. | 2025.03.01<br>2025.12.01 | 100 |
| 1.5 | Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг зээлдэгч бүрээр гаргаж, төлүүлэх | Гэрээний хугацаа бүрэн дууссан, зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид | Эхний хагас жилд 50 хувь биелэсэн | 25 хувь буюу 82.5 сая. төгрөгөөр бууруулна | 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гэрээний хугацаа дууссан 20 зээлдэгчийн 111.9 сая төгрөгийн зээл байна.<br>Өмнөх онтой харьцуулахад 8 зээлдэгч буюу 38.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн 30 зээлдэгчийн 136.0 сая төгрөгийн зээл бүрэн | 2025.03.01<br>2025.12.01 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагдсан.<br>Гэрээний хугацаа дууссан 20 зээлдэгчдээс тухайн онд 9 зээлдэгчийн 55.7 сая төгрөгийн зээл иргэний хэргийн анхан шатны шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ажиллагаа хийгдэж байна. Цаашид гэрээний хугацаа дуусаагүй боловч хугацаандаа төлөхгүй байгаа зээлдэгчдийг хяналтын зөвлөлийн гишүүдтэй хамтран төлүүлж барагдуулахаар хамтран ажиллаж байна. | | |
| 1.6 | Гэрээний нөхцөл дуусаагүй зээлдэгч нарыг хуваарийн дагуу тогтмол төлүүлэх | 2023 онд хэвийн зээлдэгчдийн төлөлт:<br>2021 оны 29 зээлдэгчийн 81.3 сая.төгрөгний<br>2022 оны 14 зээлдэгчийн 52.4 сая төгрөгний<br>2023 оны 15 зээлдэгчийн 7.9 сая төгрөгний<br>Нийт 169.3 мян.төгрөг | 100.0 сая төгрөг | 200.0 сая төгрөг | 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 40 зээлдэгчийн 489.6 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагатай байна. Үүнээс гэрээний хугацаа дууссан 20, гэрээний нөхцөл дуусаагүй 20 зээлдэгч байна. Гэрээний дагуу төлөгдөж байгаа 2022 оны гэрээний хугацаа дуусаагүй 3 зээлдэгчийн 15.2 сая төгрөг, 2023 оны 15 зээлдэгчийн 40.2 сая төгрөг, 2024 оны 4 зээлдэгчийн 30.9 сая төгрөг нийт 86.3 сая төгрөг хугацаандаа хэвийн төлөгдсөн. Сар бүр зээлдэгчидтэй утсаар холбогдон хугацаа хэтрэлт гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна. Монгол банкны мэдээллийн сангийн лавлагааны программд орсонтой холбоотой явцын хугацаа хэтрэлт багассан үзүүлэлттэй сайн талтай байна. | 2025.01.01<br>2025.12.01 | 70 |
| 1.7 | Хоршоо хөгжүүлэх сангийн мэдээллийн сангийн программд зээлдэгчдийн материалыг бүрэн шивж оруулах, Монгол банкны мэдээллийн сантай холбох | Шинээр зээл авсан зээлдэгчид Шинээр төлөгдсөн төлөлт | 100 хувь | 100 хувь | Мэдээллийн сангийн программд нийт 40 зээлдэгчдийн эргэн төлөлтийг шивж оруулан төв сервэрт илгээн ангиллыг засуулан ажиллаж байна. Программд орсноор зээлдэгчид зээлээ гэрээний дагуу төлж хэвшээд байна. 11 дүгээр сарын байдлаар зээлээ төлж барагдуулсан 30 зээлдэгчийн 136.0 сая төгрөгийн зээлийг программд шивж оруулан төв серверт илгээн хэвийн ангилалд оруулж ажилласан. | 2025.01.01<br>2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.8 | Хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн эргэн төлөлтөд хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллах | - Шүүхэд шилжүүлсэн зээлдэгчийн тоо<br>- ШШГГазарт шилжүүлсэн зээлдэгчийн тоо Нийт нэхэмжлэлийн хэмжээ | 25.0 сая төгрөгөөс доошгүй зээлийн дүнтэй нэхэмжлэлийг шүүхэд гаргах | 50 сая төгрөгөөс доошгүй нэхэмжлэлийг гаргах | 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гэрээний хугацаа дууссан 20 зээлдэгчийн 111.9 сая төгрөг байна. Үүнээс 11 дүгээр сарын байдлаар Иргэний Хэргийн Анхан Шатны шүүхэд 5 зээлдэгчийн 11.5 сая төгрөгийн зээлийг шилжүүлж, Шүүх болон ШШГГазар шилжүүлсэн зээлдэгдээс 17.6 сая төгрөг төлөгдсөн байна. Иргэний Хэргийн Анхан Шатны Шүүх болон Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Газарт 9 зээлдэгчийн 55,7 сая төгрөгийн зээл ажиллагаа хийгдэж байна. | 2025.01.01<br>2025.12.01 | 100 |
| | Хоёр. Сумын статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санг хөтөлж, холбогдох нэгж байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах | | | | | | |
| 2.1 | Сумын 2024 оны статистик мэдээ, тайлангуудыг хуваарийн агуу мэдээллэнэ. | Төл бойжилтын мэдээ – 4<br>Хорогдлын мэдээ – 3<br>Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ – 1<br>Хөрөнгө оруулалтын мэдээ -1<br>Ургац хураалтын мэдээ | Төл бойжилтын мэдээ – 2 | Төл бойжилтын мэдээ – 4<br>Хорогдлын мэдээ – 3<br>Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ – 1<br>Хөрөнгө оруулалтын мэдээ -1<br>Ургац хураалтын мэдээ | Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран хуваарийн дагуу тогтмол гарган хүргүүлж ажилласан. Шинээр ашиглалтад орсон байшин орон сууцны мэдээг 13 багийн ажлын албанаас хүлээн авч Статистикийн хэлтэст 3 дугаар улирлын байдлаар хүргүүлж ажилласан. | 2025.01.01<br>2025.12.01 | 100 |
| 2.2 | Сумын 2025 оны хагас жилийн болон жилийн эцсийн малын тооллогыг маягтыг хугацаанд баталгаажуулан хүлээн авч, мэдээллэх | Тооллого явагдаж, хугацаандаа мэдээлэгдсэн байна. | 100 хувь | 100 хувь | Хагас жилийн түүвэр тооллогын ажлын хэсгийг Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/139 дүгээр захирамжаар байгуулан ажилласан. Хагас жилийн малын түүвэр судалгаа зохион байгуулах ажил 06 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар 10-ны өдрийг дуустал явагдаж 4 чиглэлд гарч тооллогын ажлыг зохион байгуулсан. Хагас жилийн малын түүвэр судалгаанд сумын хэмжээнд 339 өрхийн жагсаалт ирж тооллогот 100 хувь хамруулж ажиллаласан. Мөн жилийн эцсийн мал | 2025.05.01<br>2025.12.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооллогыг зохион байгуулахаар ажлын хэсгийг байгуулан захирамжийн төсөл бэлтгэн заасан хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 2.3 | Багуудыг ХАӨМСанд иргэдийн бүртгэлийн өөрчлөлт, баяжилт тогтмол хийлгэж, тодруулга алдааг тухай бүр засварлуулж байна. | ХАӨМСан улирал бүр алдаагүй байх | 100 хувь | 100 хувь | Хүн ам өрхийн мэдээллийн сангийн программд өдөр бүр хяналт тавьж, алдааны протоколыг багуудад хүргүүлж тухай бүр засварлуулсан. Мөн шилжилт хөдөлгөөнийг баталгаажуулах болон хүлээгдэж буй өрхүүдийг батлуулж хасалтыг хийлгэсэн. Хүн ам орон сууцны 2025 оны завсрын тооллоготой холбогдуулан 10 дугаар сарын 20-ны өдрийн А\288 дугаартай Засаг даргын захирамжаар 32 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсантай холбогдуулан шинэ хүн ам өрхийн мэдээллийн сангийн программд иргэдийн мэдээллийг шинэчлэн баяжилтыг хийн ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.12.31 | 100 |
| 2.4 | Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар, аймаг, сумын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллах | Хяналтан авсан зүйл заалтын тоо, хэрэгжилтийн хувь | 100 хувь | 100 хувь | Сумын үндсэн чиглэлийн 4 заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 8 заалт, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 заалт, аймгийн тогтоол шийдвэрийн 10 заалт, сумын тогтоол шийдвэрийн 12 заалт нийт 40 хамааралтай заалтуудын тус тус биелэлтийг гарган Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн нэгтгүүлж ажилласан. | 2025.01.01<br>2025.12.01 | 100 |
| | Гурав. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд | | | | | | |
| 3.1 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах | Төлөвлөгөө | 100 хувь | 100 хувь | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан албаны даргаар баталгаажуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж төлөвлөгөөний дагуу хариуцсан ажлын тайлан, мэдээ, судалгаа, биелэлтүүдийг хуваарийн дагуу гарган хүргүүлж ажилласан. | 2025.01.10<br>2025.02.10 | 100 |
| 3.2 | Гэрээний хугацаа дууссан зээлдэгчдийн хувийн хэрэг болон бусад мэдээ тайлан | Зээл хаасан зээлдэгчдийн хувийн хэрэг | Тодорхойлох боломжгүй | Тодорхойлох боломжгүй | 2024 онд зээлээ бүрэн хаасан зээлдэгчдийн хувийн хэргийг хааж, архивлаж бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгч архивт шилжүүлсэн. | 2025.03.01<br>2025.03.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | архивлах | | | | Мөн тухайн онд зээл хаасан 63 зээлдэгчдийн хувийн хэргийг үдэж цэгцлэн архивт хүлээлгэн өгч ажилласан. | | |

## НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /Биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Өөрийн хариуцсан ажлын чиглэлийн дагуу Засаг даргын зөвлөлийн хуралд хугацааны дагуу мэдээлэл оруулах | Хэлэлцэх жагсаалтын дагуу хуралд оролцох | 100 | 100 | Хоршоо хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилт болон зарцуулалтын талаар Засаг даргын зөвлөлийн хурал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж зөвлөлийн гишүүдийн заавар зөвлөгөө өгсний дагуу ажилдаа тусгаж ажлын үр дүнгээ дээшлүүлэхэд анхааран ажиллаж байна. | 2025.03.01 2025.12.01 | 100 |
| 2 | Тендерийн үнэлгээний хороонд ажиллах | Үнэлгээний хорооны гишүүний үнэмлэх авсан байна | 100 | 100 | Жилийн эцсийн байдлаар 5 тендерийн үнэлгээний хороонд орж төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтыг бүрдүүлж хавтас нээн ажилласан. | 2025.01.01 2025.12.01 | 100 |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /Биелэлт/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.1 | Төсөл бичих аргачлал, төслийн эдийн засгийн тооцоолол, төлөвлөлтийн талаар мэдлэгтэй болох | Өрхийн болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд төсөлд тавигдах шаардлага, аргазүйн талаар зөвлөгөө өгөх | 100 | Цахим болон танхимаар судлах | 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр аймгийн хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан бизнесийн төсөл хэрхэн бичих талаар сургалтад хамрагдаж өрхийн болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд төсөлд тавигдах шаардлага, арга зүйн зүйн талаар мэдээлэл өгөх чадвартай болсон. . Мөн Багийн Зохион байгуулагч (Эрх зүйн хөтөч), мал аж ахуй, | 2025.01.01 2025.12.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чадвартай болох | | | газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршооны гишүүдэд 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хоршооны тухай хуулийг сурталчлах, хоршоо хөгжүүлэх сан, шинэ хоршоо хөдөлгөөн, төрөөс баримталж буй бодлого шийдвэрийг танилцуулах, хоршоо эрхлэгчдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой удирдамж, хөтөлбөр боловсруулан сургалтыг аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар, төрийн банк, аймгийн хоршоологчдын холбоотой хамтран зохион байгуулж нийт 26 иргэн оролцлоо. Сургалтаар хоршооны үйл ажиллагаа, хөнгөлттэй зээл олголт, эргэн төлөлт, сонгон шалгаруулалт, хуулийн мэдээлэл өгч хоршооны гишүүдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн. | | |
| 2.2 | Зээлийн нэгдсэн сангийн программыг бүрэн эзэмших | Программын мэдээллийг алдаагүй зөв бүртгэдэг болох | 100 | Программ дээр тогтмол баяжилт хийх | Зээлийн нэгдсэн сангийн программыг эзэмшихэд анхаарч сумдын мэргэжилтнүүдээс арга зүйн зөвлөгөө авч ажиллаж байна. Зээлдэгчдийн эргэн төлөлтийн мэдээг өдөр бүр шүүж зээлийн мэдээллийн сангийн программд бүрэн оруулж төв сервэрт мэдээллийг илгээн ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.12.31 | 100 |
| 2.3 | Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, дүрэм журмыг уншиж танилцан судлах | Төрийн албан хаагчийн эрх зүйн мэдлэгтэй болох | 100 | Уншиж судлах | Төрийн албаны тухай хууль, Статистикийн тухай хууль, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, хоршоог хөгжүүлэх сангийн журмыг өдөр тутам судлан ажиллаж байна. Мөн статистикийн хэлтэс болон хөдөө аж ахуйн газар байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад тухай бүр хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнд: Статистик мэдээ гаргах, тооллого судалгаа зохион байгуулах, бизнесийн төсөл хэрхэн бичих, бизнесийн санхүү, төлөвлөлт, сайн засаглалын тухай, бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал,бодлогын хэрэгжилт үнэлэх арга зүй, төрийн болон албаны нууцын тухай хууль, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах | 2025.01.01<br>2025.12.01 | 100<br>50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай сургалтуудад тус тус хамрагдсан. | | |
| 2.4 | Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх | Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх | 100 | Сургалтад хамрагдах | Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэхэд анхаарч төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор зарласан “Хүмүүн бичигтэн” аяны хүрээнд үндэсний бичгийн сургалтад хамрагдаж унших, гараар бичих болон компьютерт шивэх зэрэг сургалтад хамрагдаж батламж авч мэдлэгээ дээшлүүлсэн. | 2025.01.01<br>2025.12.01 | 100<br>0 |
| 2.5 | Статистикийн эмхэтгэл гаргах | Үнэн зөв гаргах | 0 | 30 | Сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт буюу статистикийн эмхэтгэлийг гаргахад 9 бүлгийн 58 төрлийн тоон үзүүлэлтүүдийг багийн ажлын алба, салбар хариуцсан мэргэжилтнүүд, Өвөрхангай аймгийн статистикийн эмхэтгэлийн баримтуудаас гарган авч нэгтгэсэн. Тус эмхэтгэлийг 80 ширхгийг хэвлэн удирдах албан тушаалтнууд, сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид, 13 багийн ажлын алба, мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгч, иргэдийг мэдээллээр хангах заавар зөвлөмжийг хүргэсэн. Тус эмхэтгэлийг байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан хэвлэж, 200,000 төгрөгний зардал гаргасан. Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлууд, улс аймгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хяналт шалгалтыг тогтмол хийж зөвлөмж, илтгэх хуудсыг хүргүүлэн ажилласан. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

| | | |
|---|---|---|
| ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН | Л.ДОРЖХАНД | 2025.12.01 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

# АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН ЛУВСАНПҮРЭВИЙН ДОРЖХАНДЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Нэгжийн нэр: САНХҮҮ АЛБА

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **“Зорилт 1. ‘Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуйг дэмжин хөнгөлөлттэй зээл олгох”-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 1.4. | 60 | 10 | 70 | |
| 5. | Арга хэмжээ 1.5. | 42 | 7 | 49 | |
| 6. | Арга хэмжээ 1.6. | 42 | 7 | 49 | |
| 7. | Арга хэмжээ 1.7. | 60 | 10 | 70 | |
| 8. | Арга хэмжээ 1.8. | 60 | 10 | 70 | |
| Зорилт 2. Сумын статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санг хөтөлж, холбогдох нэгж байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 2.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 2.3. | 60 | 10 | 70 | |
| 4. | Арга хэмжээ 2.4. | 60 | 10 | 70 | |
| Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | |
| | | | | | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо** | | | | 67.4 | |

## 2.Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 2.1 | 100 | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2.2 | 100 | 15 | 15 |
| 3. | Арга хэмжээ 2.3 | 100 | 15 | 7,5 |
| 4. | Арга хэмжээ 2.4 | 100 | 15 | 0 |
| Дундаж оноо | | | 15 | 15 / 10,5 |

2. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | | | |
| 7. | | | |
| 8. | | | |
| **Дундаж оноо** | | 7 | |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Багаар ажиллах | |
| 3. | Харилцаа | |
| **Дундаж оноо** | | |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмээ)-ын биелэлт орно)* | (70 хүртэлх оноо) 67.4 |
| 2. | Мэдлэг ур, чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | (15 хүртэлх оноо) 10,5 |
| 3. | Хандлага, ёс зүйн, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | (7 хүртэлх оноо) 7 |
| 4. | Хандлага, ёс зүйн, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | (8 хүртэлх оноо) 7,94 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | (.... оноо) |
| Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх арга хэмжээний оноо+ Хандлага, ёс зүйн, ур чадварын | | 92.8 |

| | |
|---|---|
| оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))*-Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтын дагуу хассан оноо+ Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ЗДТГАЗРЫН САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА .............................. /Ж.ГАНЗОРИГ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.12.01 *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН .............................. /Л.ДОРЖХАНД/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.01 *(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ЗДТГ-ын дарга .............................. /С.Ганчимэг/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.............................. *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

.......................................... .............................. /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.............................. *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА .............................. /С.ГАНЧИМЭГ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.............................. *(огноо)*